

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ2025 оны 01 сарын 14 өдөрДугаар: 01

Улаанбаатар хот

**Төлөвлөгөөний биелэлт
дүгнэх тухай**

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгалын багц дүрэм”-ийн 13 дугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ын 4.1, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2024 оны давхар даатгалын төлөвлөгөөний биелэлтийг багцын давхар даатгалын гэрээ (трити)-г хэрэгжүүлж ажилласан, хувь оролцооны давхар даатгалын гэрээ (факультатив)-г хэрэгжүүлж ажиллаагүй байна гэж дүгнэсүгэй.

2. 2025 оны давхар даатгалын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, факультатив гэрээний давхар даатгалд анхаарал хандуулж ажиллахыг, 2024 оны давхар даатгалын төлөвлөгөөний биелэлт, холбогдох тайланг “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-д заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороонд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын алба (Д.Дуулал)-нд даалгасугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ